



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайваны өргөн чөлөө 23, Юу Би Эйч төв, 8 давхар,  
Утас: 26 01 82

2022.03.03 № 02/01/522

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоолоор Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн цуцалсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22.1 дэх заалтад "Монгол улсад үйлдвэрлэх, импортлох, худалдах, эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна" гэж заасны дагуу Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх оношлуурыг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтээ 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн улсын бүртгэлд бүртгэгдээгүй Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх оношлуурт импортын лиценз олгохгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн улсын бүртгэлд бүртгэгдээгүй бусад урвалж, оношлуурыг 2022 ондоо багтаан бүртгүүлэх шаардлагатай байна. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс улсын бүртгэлд бүртгэгдээгүй урвалж, оношлуурт импортын лиценз олгохгүй болохыг анхааруулж байна.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.УРАНЗАЯА

142022 02289